



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Сайхандулаан сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ДГА-2022/80/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:

www.audit.mn

Дорноговь аймаг

2022 он

Дарга, тэргүүлэх аудитор: Т.Ган-Өлзий

Утас: 70522734

Аудитын менежер:

Утас: 70523020

Ахлах аудитор:

Аудитор:

Цахим хаяг: dornogovi@audit.gov.mn

У.Оюунтүлхүүр

Цахим хаяг: oyuntulkhuur.u@audit.gov.mn

Э.Энхцэцэг

Цахим хаяг: enkhtsetsege@audit.gov.mn

Т.Мөнхтогтох

Цахим хаяг: munkhtogtokht@audit.gov.mn



**ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Орон нутгийн өмчийн III байр, Залуучууд гудамж,
3 дугаар баг, Сайншанд сум, Дорноговь аймаг, 44103,

Утас: (705) 2-27-34

Бүх сайт: domogovi@audit.gov.mn

2021.08.24 № 1-6/103

танай _____-ны № _____-т

САЙХАНДУЛААН СУМЫН ИРГЭДИЙН
ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН НАРИЙН
БИЧГИЙН ДАРГА М.БАТЦЭЦЭГ ТАНАА

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Сайхандулаан сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Сайхандулаан сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторов баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторов ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР _____ Т.ГАН-ӨЛЗИЙ

010020056

Нэг. Санхүүгийн ба төсвийн гүйцэтгэлийн тайлангийн гол үзүүлэлтүүд

		/сая төгрөгөөр/	
	Үзүүлэлт	2020.12.31	2021.12.31
Санхүүгийн байдлын тайлан			
	Эргэлтийн хөрөнгийн дүн	1.1	1.2
	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	2.1	1.7
	Нийт хөрөнгийн дүн	3.2	2.9
	Нийт өр төлбөрийн дүн	-	-
	Цэвэр хөрөнгө/өмчийн дүн	3.2	2.9
	Өр төлбөр, цэвэр хөрөнгө/өмчийн дүн	3.2	2.9
Санхүүгийн үр дүнгийн тайлан			
	Үйл ажиллагааны орлогын дүн	67.8	67.6
	Үйл ажиллагааны зардлын дүн	67.2	67.9
	Үйл ажиллагааны үр дүн	0.6	0.3
	Үйл ажиллагааны бус үр дүн	-	-
	Үйл ажиллагааны нийт үр дүн	0.6	0.3
Мөнгөн гүйлгээний тайлан			
	Үйл ажиллагааны мөнгөн орлогын дүн	67.5	67.6
	Үйл ажиллагааны мөнгөн зарлагын дүн	67.5	67.6
	Үйл ажиллагааны ЦМГ	-	-
	Хөрөнгө оруулалтын ЦМГ	-	-
	Санхүүгийн ажиллагааны ЦМГ	-	-
	Нийт цэвэр мөнгөн гүйлгээ	-	-
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-
Цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан			
	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	2.6	3.2
	Тайлант оны үр дүн	0.6	-0.3
	Эцсийн үлдэгдэл	3.2	2.9
Төсвийн гүйцэтгэлийн тайлан			
	Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн	61.9	60.3
	Урсгал зардал	61.9	60.3
	Хөрөнгийн зардал	-	-
	Зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр	61.9	60.3
	Орон нутгийн төсвөөс санхүүжих	61.9	60.3
	Төсөвт байгууллагын үйл ажиллагаанаас	-	-

Хоёр. Байгууллага, түүний үйл ажиллагаа

Сайхандулаан сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын үйл ажиллагааны эрхэм зорилго нь нутгийн өөрөө удирдах ёсны байгууллагыг чадавхжуулах, иргэдийн санаачилга дээр тулгуурлан хуулийн хүрээнд бодлого шийдвэрийг тодорхойлох, хяналт шалгалтын ажлыг зохион байгуулах, ил тод нээлттэй байдлыг хангаж ажиллахад оршино.

Байгууллагын 2021 онд дэвшүүлсэн зорилт:

- Нутгийн өөрөө удирдах байгууллагын ажлын үр нөлөө, чанар хүртээмжийг сайжруулах;
- Сумын ард иргэдийн аж амьдралыг дээшлүүлэх;
- Ая тухтай амьдрах нөхцөлийг бүрдүүлэх бодлого шийдвэрийг хуулийн хүрээнд орон нутгийн онцлогт тохируулан батлах;
- Бодлого шийдвэрийн хэрэгжилтийг хангуулах, нээлттэй, ил тод болгон төлөвшүүлэх.

Үйл ажиллагааны чиглэл нь: Төр, эдийн засаг, нийгмийн бодлогын удирдлагын үйл ажиллагаа юм.

Гурав. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Шилэн дансны цахим системд тайлант хугацаанд оруулбал зохих 149 мэдээллээс хугацаандаа оруулсан 149 мэдээлэл, хугацаа хоцроосон мэдээлэл байхгүй байна.

Дөрөв. Дараагийн аудитаар анхаарах асуудал

Анхаарал татахуйц асуудал байхгүй байна.

Тав. Аудитын илрүүлэлт:

Аудитаар нийт 0.2 сая төгрөгийн 4 алдаа зөрчил илэрснээс, 0.2 сая төгрөгийн 1 алдааг залруулж, 3 зөвлөмж өгсөн.

5.1 Залруулсан алдаа

1. Байгууллагын үндсэн хөрөнгийн дансанд 0.2 сая төгрөгийн элэгдлийг дутуу тооцсон байсныг залруулав.

5.2 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1 Тодруулгатай холбоотой асуудал

1.1 Илрүүлэлт:

Элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн 12 ширхэг 2.7 сая төгрөгийн бүртгэлтэй үндсэн хөрөнгийг шийдвэрлээгүй байна.

1.2 Өгсөн зөвлөмж:

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.3.2 “илүүдэл эд хөрөнгө болон элэгдэл хорогдлын шимтгэлээр анхны үнийг нь нөхсөн, түүнчлэн нөхөөгүй боловч гэмтэж, засаж сэлбээд өөр зориулалтаар ашиглаж болох эд хөрөнгийн үнийг төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагатай зөвшилцөн тогтоох”, 31.3.3 “засаж сэлбэн ашиглах боломжгүй эд хөрөнгийг акталж устгах” гэсэн заалттай нийцэхгүй байна.

Ашиглах боломжтой боловч ашиглалтын хугацаа дууссан хөрөнгийг үнэлж бүртгэх, шаардлага хангаагүй хөрөнгийг акталж данснаас хасах арга хэмжээ авч ажиллах.

2 Ажил гүйлгээний ангитай холбоотой асуудал

2.1 Илрүүлэлт:

Цалинг холбогдох зааврын дагуу бүртгээгүй байна.

2.2 Өгсөн зөвлөмж:

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн “6.3.2 санхүүгийн аливаа үйл ажиллагааг НББОУС-ын дагуу цаг хугацаанд нь үнэн зөв бүртгэж тайлагнах”, Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-тай нийцэхгүй байна.

Цалингийн бүртгэлийг холбогдох зааврын дагуу хийж байх.

3 Тодруулгатай холбоотой асуудал

3.1 Илрүүлэлт:

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг боловсруулж, батлуулаагүй байна.

3.2 Өгсөн зөвлөмж:

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2-д “аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага нь нягтлан бодох бүртгэлийн хууль тогтоомж, стандарт, дүрэм, журам, зааварт нийцүүлэн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг баталж, мөрдөж ажиллах”, 20 дугаар зүйлийн 20.2.2-д “аж ахуйн нэгж, байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг боловсруулах, батлуулах, хэрэгжилтийг зохион байгуулах” гэсэн заалттай нийцэхгүй байна.

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг холбогдох хууль, дүрэм, журам стандартад нийцүүлэн боловсруулж, батлуулах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 11 дүгээр сарын 10-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

6.1 Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн мэдээлэл

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
A	1	2	3	4	5	7	8	9	10
1	ТШЗ	1	1			1			
	НИЙТ	1	1			1			

6.2 Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл:

/сая төгрөгөөр/

№	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
A	1	2	3	4	5	6	7	8	9	10	11
1	Сайхандулаан сумын ИТХ	4	0.2	1	0.2	-	-	-	-	3	-
	НИЙТ	4	0.2	1	0.2	-	-	-	-	3	-